



Долоо хоног тутмын хэвлэл
2015 оны 09 дүгээр сарын 21
№35 /896/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
Их Хурлын
тогтоол

1705

Монгол Улсын
Их Хурлын
тогтоол

1706

Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн дүгнэлт

1714

Монгол Улсын Засгийн газрын
зарим гишүүнийг томилох
тухай

Ерөнхийлөгчийн хоригийн
тухай

Монгол Улсын Их Хурлын тухай
хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12
дахь заалт Үндсэн хуулийн
холбогдох заалтыг зөрчсөн эсэх
маргааныг хянан шийдвэрлэсэн
тухай



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|------|
| 442. | Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай | Дугаар 79 | 1705 |
| 443. | Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай | Дугаар 80 | 1706 |
| 444. | Ерөнхийлөгчийн хоригийн тухай | Дугаар 81 | 1706 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------|------|
| 445. | Хөдөө аж ахуйн салбарын 2015-2016 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай | Дугаар 292 | 1707 |
| 446. | Журам батлах, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 296 | 1711 |

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 447. | Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 11 | 1714 |
|------|--|-----------|------|

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр	Дугаар 79	Улаанбаатар хот
-------------------------------------	-----------	-----------------

Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдаар доор дурдсан хүмүүсийг томилсугай:

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар Цэрэндашийн Оюунбаатарыг;



2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдаар Намдагийн Батцэрэгийг;
3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдаар Баярбаатарын Болорыг.

2.Энэ тогтоолыг 2015 оны 9 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 09 дүгээр
сарын 08-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын зарим
гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдаар доор дурдсан хүмүүсийг томилсугай:

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдаар Зангадын Баянсэлэнгийг;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдаар Мөнхчулууны Зоригтыг;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөрийн сайдаар Гарьдхүүгийн Баярсайханыг.

2.Энэ тогтоолыг 2015 оны 9 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 09 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар
хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1. Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсугай.

2. Энэ тогтоолыг 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 292

Улаанбаатар
хот

**Хөдөө аж ахуйн салбарын 2015-2016 оны
өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга
хэмжээний тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай:

2.1. мал аж ахуйн салбарын 2015-2016 оны өвөлжилтийн бэлтгэл хангах талаар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах;

2.2. хадлан, тэжээл бэлтгэх техник, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч ажиллан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг заавал бүрдүүлэх;

2.3. сум дундын болон аймаг дундын отрын бүс нутгууд, хилийн зурвас газар, улсын тусгай хамгаалалттай газарт отроор өвөлжих, хаваржих өрх, малын тоог өвөл, хаврын бэлчээрийн даацад тулгуурлан тухайн бүс нутгийн өөрөө удирдах байгууллага, хамгаалалтын захиргаатай тохиролцон гэрээ байгуулан зохион байгуулах;



2.4. аймаг, сум бүр отрын бүс нутгийн хилийн заагийг эртнээс тэмдэгжүүлэн хамгаалах, энэ талаарх мэдээллийг малчид, нийт иргэдэд хүргэх арга хэмжээ зохион байгуулах;

2.5. зарим шаардлагатай хадлангийн талбайг өнжөөх, сэлгэх, өөр аймгийн нутагт хадлан бэлтгэх гэрээ, хэлэлцээ хийж зохицуулах;

2.6. малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хашаа, байрны ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг технологид заасан хугацаанд нь чанартай зохион байгуулж, мал эмнэлгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж, шуурхай удирдлагаар хангаж ажиллах;

2.7. орон нутгийн төсвийн хөрөнгөөр болон төсөл, хөтөлбөрийн хүрээнд худаг шинээр гаргах, бэлчээрийн хортон мэрэгч, шавжтай тэмцэх ажлын явцад хийх гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сайжруулах;

2.8. малын хашаа, саравч, уст цэгийг засварлах, тохижуулах, түлээ түлш бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсээ базааж, өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангахыг малчин өрх бүрт анхааруулах;

2.9. ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлтгэл, зохион байгуулалтыг хангуулан цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацаа хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах;

2.10. малчин өрх, баг, сум, аймаг шат бүхэнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг сайтар хангах шаардлагатай талаар сурталчлах.

3. Хадлан тэжээлийн нөөц бүрдүүлэх техник, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах зорилгоор БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийлүүлсэн бага оврын тракторыг орон нутгийн иргэд, хоршоод, аж ахуйн нэгжийн захиалгыг авсны үндсэн дээр хөнгөлөлттэй зээлээр олгох, эргэн төлөлтийг банк, санхүүгийн байгууллагатай хамтран зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, түргэн тусламжийн машин, багаж



хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх, нутагтаа болон отроор өвөлжиж хаваржих малчдад эрүүл мэндийн явуулын үйлчилгээ үзүүлэх хуваарь гарган аймаг, сумын эмнэлгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамба, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Өвөл, хаврын улиралд зам, давааг байнга нээлттэй байлгахад шаардлагатай хүн хүч, техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулан, техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн сайд Н.Төмөрхүүд даалгасугай.

6. Агаарын хуурайшилтаас үүдэн бэлчээрийн ургамал болон тариа, ногооны болцод сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж, гангийн нөхцөл бүрдсэн үед эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан дүгнэлт гаргуулах, үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас оруулах, мал сүргийг гантай нутгаас отроор нүүлгэн шилжүүлэх зэрэг арга хэмжээг шуурхай авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол нарт даалгасугай.

7. Мал сүргийн тоо толгой хэт их өсч бэлчээрийн даац, тэжээлийн хүрэлцээ хангамжид муугаар нөлөөлөх эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор амьд малын болон махны экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ш.Раднаасэд нарт үүрэг болгосугай.

8. Дотоодод үйлдвэрлэсэн малын тэжээлийн экспортод хяналт тавих, гадаадаас импортлох тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ш.Раднаасэдэд үүрэг болгосугай.

9. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, мал өвөлжилтийн бэлтгэлийн дүнг нэгтгэн энэ оны 11 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

**ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

Р.БУРМАА



Засгийн газрын 2015 оны 292 дугаар
тогтоолын хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН БЭЛТГЭВЭЛ ЗОХИХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН
АЮУЛГИЙН НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ

№	Аймагийн нэр	Нийт малын тоо (2014 оны эцсээр мян.тол)	Хонин толгойд шилжүүлснээр (мян.тол)	Бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүйн нөөц (тн)						Нийт аймгийн хэмжээгээр бэлтгэвэл зохих (тн)		
				Аймагийн аюулгүйн нөөц (тн)		Сум, дүүргийн аюулгүйн нөөц		Нийт сум, дүүргийн бэлтгэвэл зохих (тн)		Өвс	Тэжээл	
				Өвс	Тэжээл	Сум, дүүргийн тоо	Өвс	Тэжээл	Нийт сум, дүүргийн бэлтгэвэл зохих (тн)			
										Өвс	Тэжээл	Өвс
1	Архангай	4293.2	8508.8	400	50	19	100	30	1900	570	2300	620
2	Баян-Өлгий	1883.7	2868.9	150	30	13	50	25	650	325	800	355
3	Баянхонгор	3465.9	5030.7	250	50	20	50	30	1000	600	1250	650
4	Булган	3132.8	5857.5	300	50	16	100	30	1600	480	1900	530
5	Говь-Алтай	2578.1	3254.4	150	30	18	50	25	900	450	1050	480
6	Говьсүмбэр	339.6	469.1	22	10	3	50	30	150	90	172	100
7	Дархан-Уул	324.3	633.3	32	10	4	50	30	200	120	232	130
8	Дорноговь	1686.7	2800.2	150	30	14	50	25	700	350	850	380
9	Дорнод	1393.4	3143.7	300	50	14	50	25	700	350	1000	400
10	Дундговь	2435.6	3293.5	160	30	15	50	25	750	375	910	405
11	Завхан	2895.9	4387.3	250	50	24	100	30	2400	720	2650	770
12	Орхон	123.2	264.7	30	30	2	100	30	100	60	120	70
13	Өвөрхангай	4111.6	6413.7	320	50	19	100	30	1900	570	2220	620
14	Өмнөговь	1849.0	2652.5	140	50	15	50	30	750	450	890	500
15	Сүхбаатар	2818.2	5119.1	270	30	13	100	30	1300	390	1570	420
16	Сэлэнгэ	1471.7	2885.9	150	30	17	50	30	850	510	1000	540
17	Төв	4181.5	7482.9	380	50	27	100	50	2700	1350	3080	1400
18	Увс	2561.2	3791.9	200	50	19	50	25	950	475	1150	525
19	Ховд	2625.7	3839.4	200	50	17	50	30	850	510	1050	560
20	Хөвсгөл	4157.1	6879.6	260	50	25	100	30	2500	750	2760	800
21	Хэнтий	3268.8	5686.1	300	50	17	100	30	1700	510	2000	560
22	Улаанбаатар	381.8	935.2	50	30	9	50	30	450	270	500	300
	Дүн	51979.0	86198.2	4454	840	340			25000	10275	29454	11115



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 296

Улаанбаатар
хот

Журам батлах, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Орон сууцны тухай хуулийн 6.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Орон сууцны ипотекийн зээлийн баталгааны журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Засгийн газрын 2013 оны 200 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-ын 2.2-т “Ипотекийн зээлийн хугацаа нь 20 хүртэл жил байна.” гэсний дараа Засгийн газрын 2015 оны 256 дугаар тогтоолд заасны дагуу худалдан авсан орон сууцны үнийн дүнгийн 20 хүртэлх хувь нь зээлийн баталгаанд хамрагдсан иргэний ипотекийн зээлийн хугацаа нь 30 хүртэл жил байна.” гэж нэмсүгэй.

3. Орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 200 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-ын 2.1 дэх заалтад өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж, 2015 оны 10 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт даалгасугай.

4. Орон сууцны ипотекийн зээлийн баталгааны журмын талаар нийтэд мэдээлэх, сурталчлах арга хэмжээ авч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Д.ЦОГТБААТАР



Засгийн газрын 2015 оны 296 дугаар
тогтоолын хавсралт

ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН БАТАЛГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь ипотекийн зээлээр орон сууц худалдан авах урьдчилгаа төлбөр төлөхөд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэдийн худалдан авч байгаа орон сууцны үнийн дүнгийн 20 хүртэлх хувьд ипотекийн зээлийн баталгаа гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Урьдчилгаа төлбөрийн баталгааны нөхцөл

2.1. “Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал” MNS 6058:2009 стандартын дагуу 80 м²-аас дээшгүй талбай бүхий, инженерийн дэд бүтэц (цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга, холбоо дохиолол)-д бүрэн холбогдсон, эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглалтад хүлээн авсан шинэ орон сууц (нийтийн зориулалттай орон сууц болон амины орон сууц)-ны үнийн дүнгийн 10 хувийг бэлнээр харилцах дансанд байршуулан төлсөн, ипотекийн зээлийн шалгуур үзүүлэлтийг хангасан иргэнд тухайн орон сууцны үнийн дүнгийн 20 хүртэлх хувьд Хөгжлийн банкнаас баталгаа гаргана.

2.2. Хөгжлийн банк нь ипотекийн зээлийн баталгаа гаргахтай холбогдуулан санхүү, төсвийн болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээ байгуулна.

2.3. Хөгжлийн банкны баталгаа нь зээлдэгч орон сууцны үнийн дүнгийн 30 хувийг бүрэн төлж барагдуулах хүртэлх хугацаанд хүчинтэй байна.

Гурав. Орон сууцны ипотекийн зээлийн баталгаа гаргуулах
иргэнд тавигдах шалгуур үзүүлэлт

3.1. Энэхүү журмын дагуу орон сууцны ипотекийн зээлийн баталгаа гаргуулах хүсэлт гаргаж байгаа иргэн дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

3.1.1. 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэн байх;

3.1.2. анх удаа үндсэн зээлдэгчээр шинэ орон сууц (нийтийн зориулалттай орон сууц болон амины орон сууц)-ыг ипотекийн зээлээр худалдан авч байгаа (өөрийн өмчлөлийн тохилог, инженерийн дэд бүтцийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцгүй);

3.1.3. тогтмол орлоготой, сүүлийн 2-оос доошгүй жил нийгмийн даатгалын шимтгэл тасралтгүй төлсөн;

3.1.4. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд

болон Үндэсний Статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар баталсан аргачлал¹-ын дагуу амьжиргааны түвшингээ үнэлүүлсэн, “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-гийн ҮII-ХҮ бүлгийн иргэн байх.

Дөрөв. Орон сууцны ипотекийн зээлийн баталгаа гаргуулах иргэний хүсэлтийг хянан шийдвэрлэх

4.1. Энэхүү журмын 3.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан иргэний зээлийн хүсэлтийг арилжааны банк хүлээн авч судлан, зээл олгох эсэх талаар шийдвэр гаргана. Энэ тохиолдолд Хөгжлийн банкаар баталгаа гаргуулах хүсэлтийг холбогдох материалын хамт тус банкинд хүргүүлнэ.

4.2. Хөгжлийн банкны баталгаа гаргуулах хүсэлтэй иргэн харьяалах аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагад хандаж, “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-гаас тодорхойлолт авсан байна.

4.3. Иргэн “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэгдээгүй, эсхүл амьжиргааны түвшний үнэлгээ хийлгэсэн боловч тухайн үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрөөгүй бол уг асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг харьяалах аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагад батлагдсан маягтын дагуу өргөдөл гаргаж шийдвэрлүүлнэ.

4.4. Хөгжлийн банк энэ журмын 4.1-д заасан материалыг долоо хоног бүр холбогдох маягтын дагуу хүлээн авч, баталгааны эрхийн бичгийг багцлан ажлын 5 хоногийн дотор гаргаж өгнө.

Тав. Орон сууцны ипотекийн зээлийн баталгааг тайлагнах, хяналт тавих

5.1. Хөгжлийн банк баталгааны тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүрийн дараа сарын эхний долоо хоногт багтаан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.2. Арилжааны банк Хөгжлийн банкны баталгааны бичгийг үндэслэн олгосон ипотекийн зээлийн тухай тайланг улирал бүрийн дараа сарын эхний долоо хоногт багтаан Монголбанкинд бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Зургаа. Бусад

6.1. Энэ журмын хэрэгжилтэд барилга, хот байгуулалт болон хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

6.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

¹ Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2013 оны 123/165 дугаар хамтарсан тушаал



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2015 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 12.55 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Д.Сугар /илтгэгч/, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар О.Мөнхзулыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийвч.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн П.Баттулга, М.Мөнхжаргал, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах...” гэсний “... томилогдсон ... огцруулах...” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Иргэн П.Баттулга, М.Мөнхжаргал, Б.Төрболд, Б.Эрхэмбаяр нараас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд дараах агуулаа бүхий мэдээллийг ирүүлсэн байна:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад Монгол Улсын Их Хурал нь “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах” онцгой бүрэн эрхтэй гэжээ. Үүнийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад хуульчлахдаа Улсын Их Хурлын гишүүнд Засгийн газрын гишүүнийг огцруулах санал гаргах бүрэн эрхийг олгосон нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа

болно. Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнийг огцруулах санаачлагыг хэдийд ч гаргаж Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх боломжтой болсон жишиг тогтсоор өдийг хүрлээ. Ийнхүү Засгийн газрын гишүүнийг огцруулах санал гаргах бүрэн эрхийг олгосон нь Засгийн газрын кабинетын зарчмаар ажиллах Үндсэн хуулийн үзэл баримтлалыг алдагдуулах шалтгаан болж байна.

Үндсэн хуулийн Дөчдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.”, Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.” гэсэн нь Монгол Улсын Засгийн газар хамтын хариуцлага хүлээдэг кабинетын зарчмаар ажилладаг болохыг тодорхойлж байна. Засгийн газар кабинетын зарчмаар ажиллах гол агуулга нь Ерөнхий сайд дангаараа салбарын сайд нарынхаа ажлын талаар парламентын өмнө хариуцах бөгөөд Ерөнхий сайд ямар багтай ажиллахаа өөрөө шийднэ гэсэн хууль зүйн логик байна.

Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор Засгийн газрын бүрэн эрх эхэлдэг бөгөөд Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай асуудлыг Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэхээр Үндсэн хуульд заасан тул Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнийг огцруулах саналтай байгаа бол тэрхүү саналаа эхлээд Ерөнхий сайдад тавьж уг саналыг хүлээж аваад тухайн Засгийн газрын гишүүнийхээ асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх эсэх нь Ерөнхий сайдын бүрэн эрхийн асуудал гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэсэн нь Үндсэн хуулиар Улсын Их Хурлын гишүүнд Засгийн газрын гишүүнийг огцруулах санаачилга гаргах бүрэн эрхийг олгоогүй, харин Улсын Их Хурлын 19 ба түүнээс дээш гишүүнд Засгийн газрыг огцруулах санаачлагыг хамтарч гаргахыг зөвшөөрчээ.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах...” гэсний “... томилогдсон ... огцруулах ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.” гэжээ.



Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд дараах агуулга бүхий тайлбарыг ирүүлжээ. Үүнд:

“1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасны дагуу Улсын Их Хурал нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс гадна Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг Монголбанкны Ерөнхийлөгч, Хүний эрхийн Үндэсний комисс, Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн газар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүдийг томилдог тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад заасан “томилогддог албан тушаалтан” гэдэгт зөвхөн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн байна гэж үзэх боломжгүй.

2/ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурал нь дээрх байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, эдгээр байгууллагын албан тушаалтанд асуулга тавих, асуулт тавьж хариулт авах, тэдэнтэй холбогдсон ажил хэрэг, ёс зүйн зөрчлийг шалгаж, санал дүгнэлт гаргах зэрэг хэлбэрээр хяналт тавих бөгөөд үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүн дээрх албан тушаалтнуудыг огцруулах санал гаргах эрхтэй.

Энэ нь Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасан онцгой бүрэн эрхээ Улсын Их Хурлын гишүүний саналаар дамжуулан хэрэгжүүлэх нэг хэлбэр юм.

3/ Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно. Ийнхүү томилогдсон Засгийн газрын гишүүн нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан эрхлэх асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх ажлыг Засгийн газрын өмнөөс эрхлэн гүйцэтгэж, хариуцсан салбарын үр дүнг Ерөнхий сайдын өмнө дангаараа хариуцна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын бүтцийн байгууллага болох Байнгын хорооны хуралдаанаар Засгийн газрын гишүүд тайлангаа хэлэлцүүлж, өөрийг нь томилсон Улсын Их Хурлын хяналтад багтдаг байна.

Ийнхүү нэг талаас Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг албан тушаалаас нь огцруулах тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хариуцлага тооцуулах, нөгөө талаас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн нь Засгийн газрын гишүүнийг огцруулах саналыг Улсын Их Хуралд гаргах боломжтой.

Дээрх саналыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар огцруулах

эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах, Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээр огцрох бөгөөд энэ нь Засгийн газрын гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага хүлээх хууль зүйн үндэслэл болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтын Улсын Их Хурлаас ... томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, ..., тэдгээрийг ..., огцруулах гэсэн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс гадна Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг олон байгууллагын албан тушаалтанд хамааралтай төдийгүй “илтгэл, сонсгол хэлэлцүүлэх”, ..., “тэдгээрийг ... огцруулах” гэсэн албан тушаалтны хариуцлагыг дээшлүүлсэн, Улсын Их Хурлын хянан шалгах эрхийг баталгаажуулсан хоорондоо уялдаа холбоотой зохицуулалт юм.

Дээр дурдсаныг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр Танд уламжилж байна.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Засгийн газраас дараах агуулга бүхий тайлбарыг ирүүлсэн байна.

1. “Монгол Улсын Засгийн газар гэсэн нэр томъёо, ухагдахуунд Ерөнхий сайд, гишүүд хамаарна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүд мөн.

2. Засгийн газар /Ерөнхий сайд, гишүүд/ нь үйл ажиллагаагаа танхимын зохион байгуулалттайгаар явуулах учиртай бөгөөд бүрэн эрх нь Монгол Улсын Ерөнхий сайд томилогдсоноор эхэлж, шинэ Ерөнхий сайд томилогдсоноор дуусгавар болж байна.

Засгийн газрыг эмхлэн байгуулах болон хууль тогтоох эрх мэдлийн зүгээс буюу Улсын Их Хурлын гишүүдийн санаачлагаар Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг огцруулах журмыг Үндсэн хуульд тусгайлан заасан бөгөөд хүндэтгэн үзэх болон бусад шалтгаанаар тэдгээрийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхтэй холбогдсон харилцааг Үндсэн хуулийн органик хууль болох Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлээр зохицуулж байна.

3. Огцруулах, чөлөөлөх ойлголт нь агуулгын хувьд ялгаатай. Монгол Улсын Үндсэн хууль, түүний органик хууль болох Засгийн газрын тухай хуульд Засгийн газар /Ерөнхий сайд, гишүүд/-ыг огцруулах болон чөлөөлөх санал гаргах нөхцөл, журмыг харилцан адилгүй байдлаар тусган хуульчилсан. Тухайлбал, тодорхой шалтгааны улмаас буюу бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл Ерөнхий сайдын, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагасын санаачлагаар, мөн түүнчлэн Ерөнхийлөгчийн саналаар тус тус огцруулах асуудлыг хэлэлцдэг.



Харин биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон нөхцөлд чөлөөлж өгөх хүсэлтээ Ерөнхий сайд Улсын Их Хуралд, Засгийн газрын гишүүн Ерөнхий сайдад тус тус өргөн мэдүүлсний дараа Ерөнхий сайд, Засгийн газар гишүүдийг чөлөөлөх асуудлыг хэлэлцдэг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Засгийн газрын тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж хуульчилсны дагуу Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 5 дугаар сарын 6-ны өдөр баталсан Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Засгийн газрын гишүүн нь биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд албан тушаалаасаа чөлөөлж өгөх тухай хүсэлтээ Ерөнхий сайдад өргөн мэдүүлэхээр, мөн зүйлийн 3 дахь хэсэгт Засгийн газрын гишүүн өөрийн эрхэлсэн асуудлын хүрээний бодлогын асуудлаар Ерөнхий сайдтай, эсхүл гишүүдийн олонхитой санал зөрсөн зэргээс бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, түүнчлэн хуульд заасан бусад үндэслэл байна гэж үзвэл албан тушаалаасаа огцрох хүсэлтээ Ерөнхий сайдад хэдийд ч гаргаж болохоор тус тус хуульчилсан нь Засгийн газар танхимын зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдгийг, Засгийн газрын гишүүнийг огцруулах, чөлөөлөх асуудлыг Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд гагцхүү Ерөнхий сайдын санаачлагаар шийдвэрлэх шаардлагатайг тодотгосон зохицуулалт болно.

4. Улсын Их Хурлын санаачлагаар Засгийн газрыг огцруулах тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавьсан байх шаардлагатай байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүд тул дээр дурдсан хуулийн шаардлага Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийг огцруулах асуудлыг шийдвэрлэхэд аль алинд нь хамаарна гэж үзэж болохоор байна.

Улсын Их Хурлын гишүүн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд буюу уг хуульд зааснаас өөр журмаар Засгийн газар /Ерөнхий сайд, гишүүд/-ыг огцруулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль зүйн үндэслэлгүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүний “хууль санаачлах эрх” энэ тохиолдолд мөн хуулийн Дөчин гуравдугаар зүйлээр хязгаарлагдаж байгаа болно.

5. Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд Засгийн газрын гишүүдийг чөлөөлөх огцруулах асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь Монгол Улсын Ерөнхий сайдын бүрэн эрх болох нь тодорхой байна.

Харин Үндсэн хуулийн органик хууль болох Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд шаардлагатай тохиолдолд өөрийн бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын гишүүнийг огцруулах саналыг тухай бүр Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэх хууль зүйн боломж нээлттэй юм. Энэхүү зохицуулалт нь эрх мэдлийг харилцан хамаарал, хяналт, тэнцвэртэйгээр хэрэгжүүлэх зарчимд нийцэж байгаа бөгөөд Засгийн газар чиг үүргээ парламентын хяналт дор харьцангуй хараат бусаар тогтвортой хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой зохицуулалт юм.

Монгол Улсын Үндсэн хуульд аливаа хууль, зарлиг, төрийн байгууллагын шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохих тул Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад заасан Улсын Их Хурлын гишүүн “огцруулах санал гаргах” гэснийг Засгийн газар /Ерөнхий сайд, гишүүд/-т хамаарахгүй байхаар өөрчилж, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх нь зүйтэй байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлах, аливаа асуудлаар санал гаргах эрхтэй боловч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан тул Засгийн газрын гишүүнийг огцруулах асуудал Ерөнхий сайдын эрх хэмжээнийх байхаар зохицуулжээ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах ...” гэсний “... томилогдсон ... огцруулах ...” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн байх үндэслэлтэй байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.”, Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.” гэж заасан нь Засгийн газар хамтын хариуцлага хүлээдэг, танхимын зарчмаар ажиллах ёстойг нотолж байна. Гэтэл Засгийн газрын гишүүнийг огцруулах асуудлыг Ерөнхий сайд өргөн мэдүүлэхгүйгээр, Улсын Их Хурлын гишүүний саналаар Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байгаа нь танхимын зарчмаар ажиллах Үндсэн хуулийн үзэл баримтлалыг алдагдуулж байна.

3. Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... Засгийн газрын ... бүрэлдэхүүн, түүнд ... өөрчлөлт оруулах ...” гэснийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дахь заалтад “... Засгийн газрын гишүүнийг томилох, албан тушаалаас чөлөөлөх, огцруулах



тухай саналаа ...” гэж дэлгэрүүлэн зохицуулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС
ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах. ...” гэсний “... томилогдсон ... огцруулах ...” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах. ...” гэж заасны “... томилогдсон ... огцруулах ...” гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Ж.АМАРСАНАА

ГИШҮҮД

П.ОЧИРБАТ

Д.СУГАР

Д.СОЛОНГО

Д.ГАНЗОРИГ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 14003